



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/19/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Авлага	11
3.5.4 Бараа материал	11
3.5.6 Үндсэн хөрөнгө	12
3.5.7 Өр төлбөр	12
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.3 Зөвлөмж	18
7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар



ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
ЗАСАГ ДАРГА Ч.САРАНГЭРЭЛ ТАНАА

**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 01/241
танай _____-ны № _____-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 14-ний 04 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 46 зорилт 290 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 96.04%-тай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Төв аймгийн Зуунмод суманд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,868,370.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,157,732.6	4,501,106.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	863,355.3	3,242,250.4
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,197,369.1	1,170,905.9
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	97,008.2	87,950.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		21,771,110.4	29,454,630.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	21,771,110.4	29,454,630.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		23,928,843.0	33,955,737.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		295,332.0	319,349.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	295,332.0	319,349.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		23,633,511.0	33,636,388.0
51	Засгийн газрын хувь оролцоо		23,633,511.0	33,636,388.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		23,928,843.0	33,955,737.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,750,982.6	19,617,635.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	4,681,229.4	8,723,281.7
110	Орлогын албан татвар	4,369,057.6	7,196,739.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	4,632,787.6	7,566,765.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-263,730.0	-370,025.8
113	Хөрөнгийн албан татвар	87,669.2	216,847.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	224,502.6	1,309,694.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,027,463.5	9,320,016.2
120	Нийтлэг татварын бус орлого	9,027,463.5	9,295,373.3
122	Тусламжийн орлого	0.0	24,642.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,042,289.8	1,574,337.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,678,707.2	9,546,046.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,146,459.7	8,018,550.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,844,039.0	7,541,477.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,148,908.3	1,104,514.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,843.9	141,427.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,294,352.5	471,985.9
2104	Хангамж, бараа материалын зардал	48,559.4	180,149.3
2105	Нормативт зардал	4,438.9	7,993.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,316.8	20,436.6
2107	Томилолт, зочны зардал	1,542.5	458.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	775,613.8	3,281,926.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,333,462.9	2,332,584.8
212	ТАТААС	170,050.8	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,132,369.9	477,072.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	532,247.5	1,527,495.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	8,072,275.4	10,071,589.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	14,469,454.1	76,248.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-6,397,178.7	9,995,340.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	11,487,294.4	11,371,028.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	4,681,229.4	8,723,281.7
110	Орлогын албан татвар	4,369,057.6	7,196,739.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	4,632,787.6	7,566,765.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-263,730.0	-370,025.8
113	Хөрөнгийн албан татвар	87,669.2	216,847.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	224,502.6	1,309,694.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	98,512.3	1,214,870.8
1181	Газрын төлбөр	119,380.6	94,823.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	6,609.7	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	763,775.2	1,057,444.6
120	Нийтлэг татварын бус орлого	763,775.2	1,057,444.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,042,289.8	1,590,301.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,971,393.2	6,235,694.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,971,393.2	6,235,694.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,669,008.1	5,757,144.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,010,610.1	1,249,050.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,810.1	181,461.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,347,306.4	469,516.3
2104	Хангамж, бараа материалын зардал	54,150.8	148,539.7
2105	Нормативт зардал	6,000.0	7,993.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,323.5	21,777.2
2107	Томиллолт, зочны зардал	1,542.5	458.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	787,097.8	3,250,022.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	230,167.0	428,324.8
212	ТАТААС	170,050.8	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,132,334.3	478,550.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,515,901.2	5,135,333.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	817,292.2	2,628,837.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	817,292.2	2,628,837.8
2200	Дотоод эх үүсвэрээр	817,292.2	2,628,837.8
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-817,292.2	-2,628,837.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-183,845.1	-127,600.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	183,845.1	127,600.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	514,763.9	2,378,895.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	348,591.4	863,355.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	863,355.3	3,242,250.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,029,636.4	30,029,636.4
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,633,511.0	23,633,511.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,030,689.7	30,030,689.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,053.2	1,053.2
9	Тайлант үеийн үр дүн	-6,397,178.7	-6,397,178.7
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	23,633,511.0	23,633,511.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,641,047.7	23,641,047.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,536.7	7,536.7
19	Тайлант үеийн үр дүн	9,995,340.4	9,995,340.4
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	33,636,388.0	33,636,388.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,216,399.5	7,442,133.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,155,926.7	5,108,421.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,110,803.5	5,064,319.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,023,387.5	1,020,255.5
210101	Үндсэн цалин	649,711.2	675,675.5
210102	Нэмэгдэл	136,412.7	193,200.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,200.0	39,644.9
210104	Урамшуулал	140,463.6	85,132.5
210105	Гэрээт ажлын хөлс	54,600.0	26,602.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,923.3	127,838.7
210201	Тэтгэврийн даатгал	86,987.9	86,987.9
210202	Тэтгэмжийн даатгал	10,233.9	10,233.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,187.1	8,187.1
210204	Ажилгүйдлийн даатгал	2,046.7	2,046.7
210205	Эрүүл мэндийн даатгал	20,467.7	20,383.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,866,743.5	2,828,489.3
210301	Гэрэл, цахилгаан	495,118.4	475,026.9
210302	Түлш, халаалт	2,184,668.1	2,164,389.9
210303	Цэвэр, бохир ус	186,957.0	189,072.5
2104	Хангамж, бараа материалын зардал	108,920.0	108,028.9
210401	Бичиг хэрэг	16,250.0	15,835.3
210402	Тээвэр, шатахуун	81,450.0	81,257.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,720.0	10,572.3
210404	Ном, хэвлэл	500.0	364.0
2105	Нормативт зардал	8,000.0	7,993.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,000.0	7,993.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,654.0	51,069.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,350.0	7,800.4
210604	Урсгал засвар	43,304.0	43,269.0
2107	Томилолт, зочны зардал	2,680.8	458.0
210702	Дотоод албан томилолт	2,680.8	458.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	821,244.4	820,459.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	818,194.4	818,194.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,450.0	1,450.0
210803	Даатгалын үйлчилгээ	500.0	500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	550.0	11.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400.0	154.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150.0	150.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,250.0	99,726.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,000.0	94,476.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,250.0	5,250.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,123.2	44,102.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,123.2	44,102.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,123.2	32,326.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,000.0	11,775.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,795,287.1	2,206,110.9
221001	Их засвар	1,393,837.0	1,016,592.9
222001	Тоног төхөөрөмж	247,500.0	117,127.9
223001	Бусад хөрөнгө	1,153,950.1	1,072,390.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	265,185.7	127,600.9
230001	Эргэж төлөгдөх зээл	265,185.7	127,600.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,216,399.5	7,628,156.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	783,728.4	764,108.6
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	783,728.4	764,108.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,349,296.7	6,662,687.2
320001	Орон нутгийн төсвөөс	6,349,296.7	6,662,687.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,083,374.4	201,361.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	265,185.7	198,161.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	3,200.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	818,188.7	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	103,696.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	289,720.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70,863.0	826,193.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,863.0	612,207.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,154.3	513,317.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	82,847.8
210101	Үндсэн цалин	0.0	14,190.3
210102	Нэмэгдэл	0.0	68,657.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	8,698.0
210201	Тэтгэврийн даатгал	0.0	5,890.3
210202	Тэтгэмжийн даатгал	0.0	686.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.0	1,085.2
210204	Ажилгүйдлийн даатгал	0.0	137.3
210205	Эрүүл мэндийн даатгал	0.0	899.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	3,600.0
210302	Түлш, халаалт	0.0	3,600.0
2104	Хангамж, бараа материалын зардал	947.7	27,115.2
210402	Тээвэр, шатахуун	947.7	27,115.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500.0	29,534.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500.0	29,534.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,706.6	361,521.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,706.6	361,521.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,708.7	98,890.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,708.7	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,708.7	0.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	98,890.1
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	95,497.6
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	3,392.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	213,985.5
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	213,985.5
223001	Бусад хөрөнгө	0.0	213,985.5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	70,863.0	826,193.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,863.0	826,193.3
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,862.9	750,600.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,000.1	75,592.9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Зуунмод суманд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,868,370.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 14-ний 04 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 46 зорилт 290 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 96.04%-тай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Зуунмод сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 08-ны А/265 захирамжаар томилогдсон сумын дотоод хяналтын баг нь 2023 онд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу Зуунмод сумын харьяа төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд, удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж, ажлын дүгнэлт тайланг бичсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Аймгийн Засаг даргын захирамжаар 2021 оны 03 сард баталсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 33,955,737.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 10,026,894.1 мянган төгрөгөөр буюу 29,5 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөгөөр/
МӨНГӨН ХӨРӨНГӨ	863,355.3	3,242,250.4	2,378,895.1
АВЛАГА	1,197,369.1	1,170,905.9	-26,463.2
БАРАА МАТЕРИАЛ	97,008.2	87,950.2	-9,058.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	21,771,110.4	29,454,630.6	7,683,520.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,928,843.0	33,955,737.1	10,026,894.1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	295,332.0	319,349.1	24,017.1
Засгийн газрын хувь оролцоо	23,633,511.0	33,636,388.0	10,002,877.0
Хуримтлагдсан үр дүн	23,633,511.0	33,636,388.0	10,002,877.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	23,928,843.0	33,955,737.1	10,026,894.1

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 3,242,250.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,378,895.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь орон нутгийн ерөнхий орлогын данс 2,930,160.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,173,082.4 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 1,170,905.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 26,463.2 мянган төгрөгөөр буурсан нь Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 1,147,979.4 мянган төгрөг болж 30,869.2 мянган төгрөгөөр буурсан нөлөөлсөн байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 87,950.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 9,058.0 мянган төгрөгөөр буурсан нь ЗДТГ-ын бараа материал 48,637.3 мянган төгрөг болж 14,903.9 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 29,454,630.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,683,520.2 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын үндсэн хөрөнгө 25,686,014.1 мянган төгрөг болж, 7,922,909.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 319,349.1 мянган төгрөг болж 24,017.1 мянган төгрөгөөр өссөн нь Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын өглөг 304,919.6 мянган төгрөг болж 9,747.6 мянган төгрөгөөр өссөн, ЗДТГ-ын өглөг 10,066.3 мянган төгрөг болж нэмэгдсэн, Хоршоо хөгжүүлэх сангийн өглөг 4,363.2 мянган төгрөг болж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 33,636,388.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 10,002,877.0 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн ерөнхий орлого 2,938,011.1 мянган төгрөг болж 2,173,082.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн, ЗДТГ-ын өмч 25,733,408.6 мянган төгрөг болж 7,901,701.2 мянган төгрөгөөр өссөн тус тус нөлөөлсөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 3,242,250.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,378,895.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	863,355.3	3,242,250.4	2,378,895.1
Төгрөг	863,355.3	3,242,250.4	2,378,895.1
Төрийн сангийн харилцах	860,774.9	3,219,880.9	2,359,105.9
Арилжааны банк дахь харилцах	2,580.4	22,369.5	19,789.1
Дүн	863,355.3	3,242,250.4	2,378,895.1

Эх сурвалж: Зуунмод сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 3,219,880.9 мянган төгрөгийн 91 хувь буюу 2,930,160.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 5,7 хувь буюу 183,652.2 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 3,3 хувь буюу 106,068.0 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын үлдэгдэл арилжааны банканд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 2,378,895.1 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-н дүн цалин нэмэгдсэнтэй холбоотой 1,346,865.6 мянган төгрөгөөр, тэмдэгтийн хураамж 1,034,145.6 мянган төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

1. Төв аймгийн Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар “Цалин шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор төрийн албаны улс төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 2,525.3 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөрийн акт бичив.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,170,905.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 26,463.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	932.0	934.0	2.0
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.0	555.8	555.8
Байгууллагаас авах авлага	13,458.5	21,386.7	7,928.2
Хувь хүмүүсээс авах авлага	1,182,978.6	1,148,029.4	-34,949.2

Эх сурвалж: Зуунмод сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 1,170,905.9 мянган төгрөгийн 98,0 хувийг буюу 1,148,029.4 мянган төгрөгийг хүмүүсээс авах авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 99.9 хувь буюу 1,147,979.4 мянган төгрөг нь хоршоо, хөгжүүлэх сангийн авлага байна.

Аудитын илрүүлэлт

Засаг даргын нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга тайланд 1,170,905.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлээгүй гэж тайлагнасныг аудитын явцад залруулсан.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 87,950.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 9,058.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	561.7	379.4	-182.3
Дуусаагүй үйлдвэрлэл	7,298.3	9,501.4	2,203.1

Бэлэн бүтээгдэхүүн	7,688.3	7,045.2	-643.1
Бичиг хэргийн материал	4,986.7	4,786.6	-200.1
Аж ахуйн материал	52,523.6	38,701.8	-13,821.8
Сэлбэг хэрэгсэл	1,241.8	1,250.0	8.2
Барилгын засварын материал	302.2	876.5	574.3
Бусад хангамжийн материал	17,405.6	20,409.3	3,003.6
Мал амьтад	5,000.0	5,000.0	0.0
Дүн	97,008.2	87,950.2	-9,058.0

Эх сурвалж: Зуунмод сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 87,950.2 мянган төгрөгийн 55,3 хувийг ЗДТГ, 27,3 хувийг Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ, 13,2 хувийг ИТХ, 3,8 хувийг Хот тохижилт үйлчилгээний газар, 0,5 хувийг Хоршоо хөгжүүлэх сангийн бараа материал эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 37,394,235.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 9,427,282.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	23,649,072.1	32,880,700.9	9,231,628.8
Тээврийн хэрэгсэл	1,019,051.5	995,007.1	-24,044.4
Машин тоног төхөөрөмж	270,518.1	295,425.2	24,907.1
Тавилга эд хогшил	175,816.9	282,817.6	107,000.7
Зам гүүрийн байгууламж	56,918.6	56,918.6	0.0
Түүх соёлын дурсгалт зүйл	10,499.1	10,499.1	0.0
Бусад үндсэн хөрөнгө	1,326,156.9	1,413,946.9	87,790.0
Програм хангамж	1,735.0	1,735.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	1,457,185.0	1,457,185.0	0.0
Дүн	27,966,953.3	37,394,235.4	9,427,282.1

Эх сурвалж: Зуунмод сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 37,394,235.4 мянган төгрөгийн үлдэгдлийн 83,9 хувь буюу 31,369,925.6 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0.2 хувь буюу 91,518.1 мянган төгрөгийг ИТХ, 15,1 хувь буюу 5,646,578.2 төгрөгийг Зуунмод тохижилт үйлчилгээний газар, 0,8 хувь буюу 284,163.6 мянган төгрөгийг Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 9,427,282.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 8,497,967.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 1,043,723.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил байхгүй байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 319,349.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 24,017.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	22.8	320.2	297.4
Байгууллагад төлөх өглөг	278,222.4	282,968.4	4,746.0
Хувь хүмүүст төлөх өглөг	160.0	4,363.2	4,203.2
Татварын өглөг /ТӨҮГ/	5,332.6	28,652.6	23,320.0
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	2,165.3	0.0	-2,165.3
Дансны өглөг /ТӨҮГ/	9,428.9	3,044.6	-6,384.3
Дүн	295,332.0	319,349.1	24,017.1

Эх сурвалж: Зуунмод сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 24,017.1 мянган төгрөгөөр өссөн нь Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ-ын өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн 319,349.1 мянган төгрөгийн үлдэгдлийн 304,919.6 мянган төгрөг нь Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ, 4,363.2 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сан, 10,066.3 мянган төгрөг нь ЗДТГ-ын өглөг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил байхгүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 33,636,388.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 10,002,877.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	2,994,392.3	2,994,392.3	0.0
Дахин үнэлгээний нөөц	4,994,714.6	4,994,714.6	0.0
Хуримтлагдсан дүн	15,644,404.1	25,647,281.2	10,002,877.1
Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	23,633,511.0	33,636,388.0	10,002,877.1

Эх сурвалж: Зуунмод сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 10,002,877.1 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүнг НБББ-ын өөрчлөлтөөр 7,536.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, тайлант үеийн үр дүн 9,995,340.4 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Зуунмод сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн “Сумын 2023 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолоор 2023 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 5,278,728.4 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 6,622,054.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 01 дугаар тогтоолд зааснаар Зуунмод сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 6,780,352.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталж, гүйцэтгэлээр 9,171,327,778.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 135,1 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх орлого 1,050.0 мянган төгрөгөөр галт зэвсгийн татвар, 25,541.9 мянган төгрөгөөр газрын төлбөр, 7,000.0 мянган төгрөгөөр ус ашигласны төлбөр, 62,582.0 мянган төгрөгөөр хог хаягдлын хураамж, 50,000.0 мянган төгрөгөөр газрын дуудлага худалдааны орлого, 6,000.0 мянган төгрөгөөр түрээсийн орлого, 128,502.8 мянган төгрөгөөр хүү торгуулийн орлого, нийт 280,676.7 мянган төгрөгөөр тасарсан байна.

Төв аймгийн Зуунмод сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 01 дугаар тогтоолоор Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 986,843.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 6,902,119.6 мянган төгрөгөөр тодотгон, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөөнд 158,591.40 мянган төгрөг, шилжих үлдэгдлийн төлөвлөгөөнд 100,000.0 мянган төгрөгөөр өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 26 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 6,780,352.0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 783,728.4 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 750,000.0 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 68,188.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 8,216,399.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 588,242.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,628,156.7 мянган төгрөг буюу 92,5 хувьтай байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
№	Хөтөлбөр	Зарцуулах төсөв	Зарцуулсан	Зөрүү	Биелэлт
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	197,176.6	195,460.7	1,715.9	99.1%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	3,338,911.5	2,942,272.6	396,638.9	88.1%
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	265,185.7	198,161.0	67,024.7	74.7%
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	1,559,040.1	1,557,748.2	1,291.9	99.9%
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	754,381.6	728,014.0	26,367.6	96.5%
6	71702-Соёлын үйлчилгээ	114,594.1	105,158.3	9,435.8	91.8%
7	70106-Орон нутгийн хөгжлийн сан	851,917.1	767,308.6	84,608.5	90.1%
8	71502- Хот тохижуулах газар	1,135,192.3	1,134,033.3	1,159.0	99.9%
Дүн		8,216,399.0	7,628,156.7	588,242.3	92.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 791,773.6 мянган төгрөг, ИТХ 34,419.7 мянган төгрөг, нийт 826,193.3 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/							
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн		Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	Сумын төлөөлөгч, тэргүүлэгчдийн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, хуралдааныг зохион байгуулж, шаардлагатай	ИТХ-ын бүрэн хэрэгжүүлэхэд ажил хангах бүхий аппарат бүрдүүлж, зохион	Сумын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, ИТХ-ын,	197,176.6	195,460.7

			мэдээллээр тасралтгүй хангахад оршино. Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж жилд 7 удаа хуралдсан байна. Хэрэгжилт 99.13%		
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 4 зорилт, хэрэгжүүлэх 8 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 88%	3,338,911.5	2,942,272.6
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	2023 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх. Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	2023 онд Хоршоо хөгжүүлэх сангаас нийт 7 зээлдэгчдэд нийт 115.000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна. Хэрэгжилт 75%	265,185.7	198,161.0
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01 2023.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 1 зорилт 3 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%.	1,559,040.1	1,557,748.2
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01 2023.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 1 зорилт 3 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 97%	754,381.6	728,014.0
	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Соёлын төв нь 1 зорилт 3 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 92%	114,594.1	105,158.3
6	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт он дамжин хийгдэх 1 төсөл, шинээр хэрэгжих 10 төслийг 395,033.6 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 25, хэрэгжээгүй 4 хөрөнгө оруулалтын ажил, хэрэгжилт 90%	851,917.1	767,308.6
7	71502- Хот тохижуулах газар	2023.01.01 2023.12.31	Хот тохижуулах газар нь 3 зорилт 6 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	1,135,192.3	1,134,033.3

Зуунмод сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 45 бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар 3,017,640.1 мянган төгрөгөөр баталсан ба 45 бараа, ажил үйлчилгээг 2,415,525.7 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

ИТХ, ЗДТГ, ХТГ, ЕБС, СӨБ, Соёлын төвийн 245,500.0 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтаар зарласан боловч санал ирүүлсэн оролцогч байхгүй байсан тул шууд худалдан авалт хийсэн байна.

ЕБС, СӨБ-ийн 1,195,596.8 мянган төгрөгийн хоол хүнс, үдийн цайны материал нийлүүлэх 11 багц худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалт болон тендер шалгаруулалтын онцгой журмаар зарласан бөгөөд Жити эко фүүд ХХК шалгаран гэрээ байгуулж хүнсний материал нийлүүлсэн ба оролцогч ирээгүй багцууд дээр шууд худалдан авалт хийсэн байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 11 төсөл арга хэмжээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Үүнээс:

Худалдан авах ажиллагааны 7 төсөл арга хэмжээг 275,115.1 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр худалдан авалтыг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 3 ажлыг

484,021.9 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 1 зураг төсөв хийлгэх 49,000.0 мянган төгрөгийн ажлыг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар зарласан байна.

Худалдан авах ажиллагааны Баянхошуу, Зүүндэлгэр, Баруун Зуунмод багуудын шинэ суурьшлын бүсийн цахилгаан, шугам сүлжээний зураг төсөв хийлгэх ажлыг Проектватт ХХК, Нацагдорж багийн нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг, ЦДАШ-0,4 кВ-ын сүлжээний ажлыг Төв гэрэл ХХК, Ланс багийн хашаанд байгаа 2 давхар байшинг засварлаж ахуй үйлчилгээний төв бий болгох ажлыг Тусгал төв ХХК, Номт багийн нийтийн эзэмшлийн орон сууцуудын явган зам, гэрэлтүүлэг, гадна талбайн тохижилт /7,8,9,10,16,17,26,28 байрнууд/-ын ажлыг Би си си би ХХК, номт багийн хөгжил хотхоны гэрэлтүүлгийн ажлыг Төв гэрэл ХХК, Нацагдорж багийн нутаг дэвсгэрт байгаа тоглоомын талбайг засварлах ажлыг Тумбааш ХХК, Баянхошуу жишиг хороолол болон хөтлийн айл өрхөд гудамжны гэрэлтүүлэг тавих ажлыг Төв гэрэл ХХК, Баянхошуу багийн хөтлийн дээд талбайн айлууд руу цахилгаан тавих ЦДАШ-0,4 кВ-ын сүлжээний ажлыг Эрчим өгий ХХК, Зүүндэлгэр багт гудамжны гэрэлтүүлэг хийх ажлыг Төв гэрэл ХХК, Баруун Зуунмод багийн 40,41-р байрны тоглоомын талбайг засаж сайжруулах, тохижилт, явган зам, Зүүндэлгэр багт явган хүний зам хийх ажлыг Би си си би ХХК, Эрчим хүчний сүлжээний өргөтгөл, засвар, 0.4кВ-н ЦДАШ-н өргөтгөл (Зуунмод Нацагдорж баг, Зүүндэлгэр баг, Ланс баг, Баруун Зуунмод Жишиг-2 хороолол)-ийн ажлыг Эрчим өгий ХХК, Ингүүмэл эрчим ХХК хийж гүйцэтгэхээр тус тус шалгаран хийж гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн төсвөөс 23 бараа ажил үйлчилгээг 1,732,228.3 мянган төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн байна. Үүнээс 5 ажлыг 747,500.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 18 бараа, ажлыг 984,728.3 мянган төгрөгөөр худалдан авахаар тендер шалгаруулалтын онцгой журмаар зарласан байна.

Худалдан авах ажиллагаанд Төв гэрэл ХХК, Лантмон ХХК, Инносолюшн ХХК, Сэрүүн хараат ХХК, Тантра энержи ХХК, Тунбааш төв ХХК, Лут өрнөх ХХК, Би си си би ХХК, Тусгал төв ХХК, Хэрмэн шар үзүүр ХХК, Өгөөмөр уул ХХК, Баяр нэтворкс групп, Эс би жи глобал ХХК, Би си ти ХХК, Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ тус тус шалгаран дээрх бараа, ажил үйлчилгээг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 05/143 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын 2022 оны нэгтгэсэн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлого 14,641,384.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 219,620.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 164,715.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 178 мэдээлэл байршуулахаас 157 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 21 мэдээлэл хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,040,117.5 мянган төгрөгийн 46 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 5,961,391.4 мянган төгрөгийн 32 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 44 мэдээлэл хугацаанд нь байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт: Зуунмод сумын Хоршоо хөгжүүлэх сан Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 39,566.00 мянган төгрөгийн 6 гүйлгээ, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 125,000.0 мянган төгрөгийн 8 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байсныг аудитын явцад нөхөн мэдээлсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийж, аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 06/397 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	88,854.0	1	88,854.0	100
Зөвлөмж					
Нийт дүн	1	88,854.0	1	88,854.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын ОНХС-ийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудлыг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,170,905.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 1,170,905.9 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Засаг даргын нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга тайланд 1,170,905.9 мянган төгрөгийн авлагын насжилтыг оруулаагүй, тооцоо нийлээгүй гэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 291,619.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 291,619.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 135,1 хувиар давж биелсэн боловч галт зэвсгийн албан татвар, газрын төлбөр, ус ашигласны төлбөр, хог хаягдлын хураамж, газрын дуудлага худалдааны орлого, түрээсийн орлого, хүү торгуулийн орлого нь 25,9-100 хувиар буюу 280,676.7 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу

хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх

2. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орлогын гүйцэтгэлийн тодруулга тайланд төсвийн орлогын гүйцэтгэлийг 9,171,327.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийг аймгийн Татварын хэлтсийн аудитад ирүүлсэн 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлээс 10,943.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын байцаагчтай орлогын дүнг сар улирлаар тохирч байх.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд байршуулбал зохих 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн төлөвтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
5	Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ	1	1				1		
	НИЙТ	5	2	3		1	1		

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул ааргүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	1,170,905.9	1	1,170,905.9			1	1,170,905.9				
ИТХ	1	107,841.24	1	107,841.24			1	107,841.24				
ЗДТГ	2	3,459,732.5	1	3,449,862.5	1	9,870.0	2	3,459,732.5				
ХХС	2	715,502.18	1	257,004.48	1	458,497.70	2	715,502.18				
Дүн	6	5,453,981.8	4	4,985,614.1	2	468,367.7	6	5,453,981.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	2	291,619.7					2	291,619.7				
ИТХ	1	2,353.1	1	2,353.1								
ЗДТГ	6	28,013.1	3	22,905.1	1	5,108.0	2	-				
Зуунмод цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ	4	164,651.6			2	42,382.5	2	122,269.1				
Дүн	13	486,637.5	4	25,258.2	3	47,490.5	6	413,888.8				

